



Диезезни харита Плзень

ПЛЗЕНЬ ДАХЬ ГАДААДЫН ИРГЭД БА ДҮРВЭГСДЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТӨВ

ЧЕХ УЛСАД АЖИЛЛАДАГ ГАДААД АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН АНХААРУУЛГА!

Бид зарим ажил олгогч нар нь гадаадын ажилчдынхаа төлөө хариуцах хариуцлагаасаа салах оролдлоготой байгааг тэмдэглэж авсан. Хэрэв таны ажил олгогч нар хожим бөглөх зорилготой (ялангуяа он, сар, өдөр) хоосон зайтай, ойлгогдохгүй баримт бичигт гарын үсэг зурруулахаар өгвөл гарын үсгээ бүү зураарай. Хэрэв боломжтой бол гарын үсгээ дараа нь зурья гэж аваад баримтын агуулгыг тусламж аван тайлбарлуулаарай. Хэрвээ шахалт шаардлагын доор гарын үсгээ зурахаас өөр аргагүй байгаа бол төрөлх хэл дээрээ “ би агуулгыг ойлгоогүй ч гарын үсгээ зурлаа ” гэж бичээрэй. Учир нь ажлын гэрээ цуцлах, төлбөргүй ажлын бус өдрүүд олгох өргөдөл зэрэг баримтууд байж болох юм. Онцгой байдал зарлагдсан энэ үед таны ажлын гэрээ хүчинтэй байгаа ч гэсэн ажил олгогч тань таниар ажил хийлгэхгүй байгаа бол та бохир цалингийнхаа 60-80% -ийг авах эрхтэй(зарим үед 100%). Хэрэв та эхний гурван сар-сургалтынхаа хугацаанд ажиллаж байгаа бол ажил олгогч тантай хэзээ ч ажлын гэрээ цуцлаж болох боловч өвчтэй байх үеийн чинь эхний 14 хоног эсвэл хөл хорио тогтоогдсон бүх хугацааны турш таны ажлын гэрээг цуцлах ёсгүй. Сургалтын хугацаа энэ өдрүүдийн тоогоор сунгагдана. Таны сургалтын үеийн хугацаа таны өвчтэй(акттай) өдрүүд, ээлжит амралтаа авсан өдрүүд мөн онцгой байдал зарлагдсан үеийн үйл ажиллагаанаас болоод ажиллаагүй өдрүүдийн тоогоор уртасна.

Онцгой байдал зарлагдсан энэ үед хэрэв та Чех улсад хуулийн дагуу оршин суух зөвшөөрөлтэй, мөн хэрвээ таны оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусч байгаа бол оршин суух зөвшөөрлөө шийдэх асуудлаа хөөцөлдөх албагүйгээр Чех улсад байж болно. Хэрэв таны ажилчны үнэмлэхийн хугацаа 6 сараас богино бөгөөд ажлын гэрээ чинь дуусч байгаа бол өөр ажил олгогчоо олоод Чех улсын дотоод явдлын яаманд ажил олгогчоо сольж байгаа тухай мэдэгдлээ өгөөрэй. Онцгой байдал зарлагдсан энэ хугацаанд нэг ажил олгогчид ажил хийж гүйцэтгэх 6 сарын хугацааг баримтлах шаардлагагүй.

COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх тухай гадаадын иргэдэд зориулсан мэдээ мэдээлэл болон эрх үүрэг нь Дотоод явдлын яамны вэбсайт-д нийтлэгдсэн байгаа учир олж уншихыг зөвлөж байна. <https://www.mvcr.cz/clanek/nove-povinnosti-a-informace-pro-cizince-prevence-rozsireni-covid-19.aspx>

Хөдөлмөрийн ба нийгмийн зүйлсийн яам <https://www.mpsv.cz/>

Хаягтаа хөдөлмөрлөх эрхтэй холбоотой шинэ мэдээ мэдээлэлийг нийтэлж байна.

Гадаадын иргэдэд ба дүрвэгсдэд зориулсан зөвлөлгөөний төвтэй шаардлага гарвал харьцаж болно.



Bc. Hana Kozlová - 731 433 027
Bc. Petra Chalupská - 731 433 008
Elizabet Kirilova 773 - 271 474
Světlna Černopaščenko - 731 433 139



poradna@dchp.charita.cz

Denisa Viktorová, DiS. - 731 433 060
Mgr. Monika Brůhová - 731 591 883
Mgr. Klára Zachová - 731 433 096
(vedoucí)

